



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2019 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/53

Ховд

**Үнэлгээний хороо байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Ховд аймгийн Цэцэг сумын нутаг дэвсгэрт шинээр баригдах 4.9 км урттай авто замын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга: Ш.Нохойжав - Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: С.Мөнх-Очир –Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,  
Төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Дэлгэрмаа - Төрийн бус байгууллагын төлөөлөл

Ж.Ганболд - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

Г.Нэмэхбаяр – Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах  
ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ш.Нохойжав/-нд үүрэг болгосугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Г.Нэмэхбаяр/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД